



ФУТЗАЛЫН СОНИРХОГЧДЫН ЦОМ - 2024

ЗААВАР

2024.11.11



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монгол улсад футзалын спортыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд МХБХ-ны "Футзалын Сонирхогчдын ЧАШТ" /цаашид ЧАШТ гэх/-ийг, Монголын Хөлбөмбөгийн Холбоо /цаашид МХБХ гэх/ бодлогын хүрээнд зохион байгуулахад оршино.
- 1.2 Футзалын клубуудийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд бэлтгэх.

ХОЁР. ЛИГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.11 МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс /цаашид "ТЗБХ" гэх/ нь, Олон Улсын хөлбөмбөгийн холбоо /цаашид "FIFA" гэх/, Азийн Хөлбөмбөгийн холбоо /цаашид "АFC"/, Монголын Хөлбөмбөгийн Холбоо /МХБХ/-ны дүрэм, журмуудыг болон бусад эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн зохион байгуулна.
- 2.1.2 МХБХ-ны эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаагүй аливаа асуудлыг FIFA болон АFC-гийн эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөнө.
- 2.13 Тэмцээн эхлэх хугацаа /2024.12.07 - 14/
- 2.14 Тэмцээний бүх үйл ажиллагаа МХБХ-ны "Тэмцээн зохион байгуулах журам"-ын дагуу явагдана
- 2.15 2024 оны Футзалын Сонирхогчдын Цом тэмцээн нь холимог системээр явагдана. Багчуудыг хэсэгт хувааж хэсгээс шалгарсан багчууд хасагдах системээр тоглоно.
- 2.16 Тэмцээнд оролцох багийн харьяалагдах Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ТЗБХ-т мэдүүлэгтэйгээ хамт хүлээлгэж өгөх шаардлагатай (спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй байх). Тоглолт 2 үеэр тус бүр 20 минут цэвэр цагаар, дундаа 10 минутын завсарлагаатай үргэлжилнэ.
- 2.17 Футзалын Сонирхогчдын Цомын тэмцээнд Монголын Дээд Лиг 2024/2025-ны улиралд бүртгэлтэй тоглогчид оролцох боломжгүй.
- 2.18 Тоглогч бүр тухайн харьяалагдаж буй багтаа байгуулсан гэрээтэй байна.
- 2.19 Тэмцээний шилдэг үзүүлэлт бүхий баг эсвэл багчууд МХБХ-ны Футзалын Нэгдүгээр Лиг 2024-2025 оролцох эрх авна. Лигийн эрх авах багийн тоог тэмцээний зөвлөгөөн дээр эцэслэсэн байдлаар танилцуулна.
- 2.110 Хэрэв Лигийн эрхийг авсан баг нь хөлбөмбөг болон футзалын улиралд зэрэг тоглох бол хоёр зэрэг тоглолтод оролцохуйц нөөц тамирчидтай байна.
- 2.111 Тэмцээнд оролцох клуб, багийг төлөөлж зөвхөн 1 баг оролцоно.
- 2.112 МХБХ-ны Лигийн үеэр ТЗБХ-т хандсан хүсэлт гомдлыг зөвхөн бичгээр хүлээн авна. Тоглолтын шүүлттэй холбоотой аливаа гомдлыг хүлээн авахгүй.
- 2.113 Сонирхогчдын Цомын тэмцээнд Нэгдүгээр Лигийн эрхийн төлөө тоглох үндсэн зорилготой ба, хэрэв шагналт байрт шалгарч цаашид Лигт оролцох боломжгүй гэдгээ илэрхийлсэн тохиолдолд шагналыг багт хүлээлгэж өгөхгүй болно.
- 2.114 Тэмцээнд оролцох гадаад тоглогчдын тог ТЗБХ-д тусгасны дагуу тоглох эрхийг олгоно.
- 2.115 Тоглолт 2 үеэр тус бүр 15 минут цэвэр цагаар, үе хооронд 10 минутын завсарлагаатай үргэлжилнэ.
- 2.116 Багийн бүрэлдэхүүнд нийт 25 тоглогч бүртгүүлэх боломжтой ба 4 албаны хүн байна. Үүнд: Ахлах дасгалжуулагч (MFF Level -1 ба түүнээс дээш), туслах дасгалжуулагч (MFF Level -1 ба түүнээс дээш), багийн менежер байна.
- 2.117 Тоглолт бүрийн өмнө багийн бүрэлдэхүүнээс 14 тоглогчийг сонгож тухайн тоглолтод оролцоно.
- 2.118 Тоглолтод хамгийн багадаа 3 тоглогч эхлэхээс өмнө бэлэн байж тоглолт эхлэх боломжтой болно. Хүрээгүй тохиолдолд эсрэг багт техникийн хонил (5-0) олгоно.
- 2.119 Тэмцээнд оролцох багчуудын эрхийн төлбөр 500,000₮ байна. Төлбөрийг МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаана.
Голомт Банк : 3015101105 Монголын Хөлбөмбөгийн Холбоо
- 2.120 Тэмцээнд зөвхөн мэдүүлэгт тусгагдсан дасгалжуулагч, тоглогч нар оролцоно.
- 2.121 МХБХ-ноос зохион байгуулсан тэмцээний тоглолт бүрт, шүүгчийн шийдвэр эцсийнх байна.
- 2.122 МХБХ-ны тэмцээний үеэр ТЗБХ-т хандсан хүсэлт гомдлыг зөвхөн бичгээр хүлээн авна. Тоглолтын шүүлттэй холбоотой аливаа гомдлыг хүлээн авахгүй.



- 2.1.23 Тэмцээний тоглолтын үеэр сахилга эсвэл хуучдастай холбоотой асуудал гарсан тохиолдолд ТЗБЖ-ын дагчу бичлэг үзэж нөхөж шийдвэрлэх боломжтой.
- 2.1.24 Багууд тоглолт эхлэхээс 60 минутын өмнө талбайд ирсэн байх шаардлагатай. Тоглолтын протоколыг тоглолт эхлэхээс 40 минутын өмнө ТЗБЖ-ээс томилогдсон тоглолт зохион байгуулагчид хүлээлгэж өгнө. Мөн энэ үеэр багийн тоглогч нарын хувцас хэрэглэлийн шалгалтыг хийнэ. Протоколыг тоглолт зохион байгуулагч болон багийн ахлах дасгалжуулагч гарын үсэг зурснаар хүчинтэйд тооцож хэвлэл мэдээлэл болон шаардлагатай бүх сүлжээнд тараагдана. Тоглолт эхэлсний дараа нэмэгдэж ирсэн тоглогчийг тоглолтод оролцуулахгүй.
- 2.1.25 Тоглолтын протоколыг тогтоосон хугацаанд бөглөж ирүүлээгүй улмаас тоглолт эхлэх хугацааг хойшлуулсан тохиолдолд багт сахилгын арга хэмжээ авна.
- 2.1.26 Тэмцээний нэг тоглолтод нэг багийн 5 тоглогч шар хуучдсаар торгуулсан тохиолдолд тухайн багийг 100,000₮ торгох болно. Тухайн тоглолтод 6 ба түүнээс дээш дараалсан шар хуучдас авсан тоглогч тус бүрийг 20,000₮ торгоно. Шүүд улаан хуучдсаар торгуулсан тоглогчийг 50,000₮ торгоно. Торгуулийг дараагийн тоглолтын өмнө МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаасан байна. Торгуулийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд торгуулийн дүн тоглолт болгоны тоогоор 2 дахин нэмэгдэх болно.
- 2.1.27 Хуучдасны болон сахилгын өнжих шийтгэлүүд нь МХБХ-ны футзалын бүх тэмцээнд хүчинтэй үйлчилнэ.
- 2.1.28 Тоглолт наймаалцах, Тэмцээний явцад ямар нэгэн байдлаар өөрийн багтаа ашигтайгаар нөлөөлөх үйлдэл хийх, бусад багуудын эрх ашигт ноцтойгоор халдаж Тэмцээний зохион байгуулалтад хундрэл учруулсан нь нотлогдвол МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ийн дагчу тус тус хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВ. БАГИЙН АЛБАНЫ ХҮНИЙ ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА

- 3.1.1 Багийн менежер, ахлах болон туслах дасгалжуулагч, ахлагч нар нь хариуцсан чиглэлээ төлөөлөх бүрэн чадвартай байж эрх, үүргээ ухамсарласан байна.
- 3.1.2 Багийн менежер нь тухайн багийн мэдээлэл МХБХ-ноос өгч буй мэдээллийг багтаа дамжуулах, багаа төлөөлөх эрх бүхий албан тушаалтан байна.
- 3.1.3 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь тоглолтын шүүгчийн шийдвэртэй холбоотой аливаа эсэргүүцлийг сонин хэвлэл, телевиз болон цахим орчин ашиглаж олон нийтэд цацахыг хориглох ба зөрчсөн тохиолдолд МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагчу арга хэмжээ авна.
- 3.1.4 Тэмцээнд оролцох дасгалжуулагч нь зөвхөн МХБХ-ны Техникийн хэлтсээс олгосон "Дасгалжуулагчийн лиценз"-тэй байж тоглолтод оролцоно. Тэмцээнд лицензтэй дасгалжуулагч байхгүй тохиолдолд тоглолт эхлэхгүй. Тоглолтыг цуцалж эсрэг багт 5-0 гэсэн хожлыг олгоно.
- 3.1.5 Техникийн бүсээс чөлөөлөгдсөний дараа дасгалжуулагч нь үзэгчийн сүүдлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд тухайн албаны хүнийг МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагчу торгоно.
- 3.1.6 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь үзэгчдийн сүүдлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагчу торгоно.
- 3.1.7 Хэрэв тоглолтын явцад аливаа шалтгаанаар дасгалжуулагчгүй (багийн менежерт хамаарахгүй) болсон тохиолдолд тухайн баг нь Time-Out хийх эрхгүй тоглолтыг дучусгана.
- 3.1.8 Дасгалжуулагч нь клубтэй хийсэн гэрээгээ ТЗБЖ-т заавал бүртгүүлнэ.
- 3.1.9 Мэдүүлэгт мэдүүлсэн дасгалжуулагчдыг зөвхөн Техникийн хэлтсийн зөвшөөрлөөр тэмцээнд оролцуулна.



ДӨРӨВ. БҮРТГЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

- 4.1.1 Тэмцээнд оролцож байгаа бүх тоглогчид FIFA CONNECT системд заавал бүртгүүлнэ. Бүртгэлд ороогүй тоглогчдыг тоглолтод оролцуулахгүй.
- 4.1.2 Тэмцээнд оролцох багийн мэдүүлгийг МХБХ-ны ТЗБХ-д 2024 оны 11 дүгээр сарын 25 -ны 17:00 цагаас өмнө зөвхөн **MEUULEGMFF@GMAIL.COM** хаягаар явуулна. Мэдүүлэгтэй хамт Тэмцээнд оролцох эрхийн төлбөр төлсөн баримтыг хамт өгнө.
- 4.1.3 Албан ёсны мэдүүлгийн анкет болон бусад шаардлагатай хавсралт материалуудыг зөвхөн XLSX (EXCEL SHEET) форматаар явуулсан тохиолдолд хүчинтэйд тооцно. Өөр цахим хаяг болон олон нийтийн сүлжээгээр явуулсан мэдүүлгийг хүлээн авахгүй.
- 4.1.4 Дээрх хугацаанаас хоцорсон мөн зохих шаардлагын дагучуу явуулаагүй мэдүүлгийг авч хэлэлцэхгүй.
- 4.1.5 Талбай дээр тоглох гадаад тоглогчийн тоо 1 байна. Гадаад тоглогч дараах материалуудыг бүрдүүлж өгсний үндсэн дээр ТЗБХ-ээс тоглох эрхээ авна. Үүнд:
- A. FIFA-гийн "Шилжилт хөдөлгөөний журам"-ын дагучуу өөрийн улсын Хөлбөмбөгийн Холбооноос Монгол улсын клубт тоглож болно гэсэн албан ёсны зөвшөөрөл,
 - B. Монгол улсын Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас тухайн тоглогч нь Монгол улсад хуулийн дагучуу ажиллаж амьдрах зөвшөөрлийн бичиг,
 - C. Паспортын хуулбар,
 - D. Тухайн тоглогчийг тоглуулах клубийн албан ёсны хүсэлт ба Монгол улсад байрлах албан ёсны хаяг,
 - E. FIFA CONNECT БҮРТГЭЛ
- 4.1.6 МОНГОЛ УЛСЫН ИРГЭН МЭДҮҮЛЭГТ БҮРТГҮҮЛЭХДЭЭ ДАРААХ МАТЕРИАЛУУДЫГ БҮРДҮҮЛНЭ.
ҮҮНД: **ТОГЛОГЧ ТУХАЙН КЛУБ, БАГТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ,**
- 4.1.7 БАГИЙН МЭДҮҮЛГИЙГ МХБХ-НЫ ЛИГИЙН ЗААВАРТ ЗААСАН ХУГАЦААНД, ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРЭН БҮРДҮҮЛЖ, ӨГНӨ.
- 4.1.8 КЛУБ, БАГУУД ТУХАЙН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ҮНДСЭН БА ТУСЛАХ ХУВЦАСНЫ ӨНГИЙГ ТЗБЖ-ЫН ХАВСРАЛТ 2-ААР ИРҮҮЛНЭ.
- 4.1.9 ДАРААХ ШААРДЛАГУУДЫГ ХАНГААГҮЙ МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭЖ АВАХГҮЙ. ҮҮНД:
- A. ЗУРАГ /СҮҮЛИЙН 6 САРД АВАХУУЛСАН/ ДУТУУ БОЛОН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ,
 - B. МЭДҮҮЛЭГ БАТАЛГААТ ГАРЫН ҮСЭГГҮЙ,
 - C. БАГИЙН МЕНЕЖЕРИЙН УТАСНЫ ДУГААР БОЛОН ЦАХИМ ХАЯГГҮЙ,
 - D. ХУВИЙН ДУГААРГҮЙ, /1 ДУГААРЫГ ЗӨВХӨН ХААЛГАЧ ӨМСӨНӨ, 0 ДУГААРТАЙ ТОГЛОГЧ БАЙХ БОЛОМЖГҮЙ/
 - E. РЕГИСТРИЙН ДУГААРГҮЙ,
 - F. ОВОГ, НЭР ДУТУУ,
 - G. ТЗБЖ-ЫН ХАВСРАЛТ 1 БҮРДҮҮЛЭЭГҮЙ,
 - H. ТЗБЖ-ЫН ХАВСРАЛТ 2 БҮРДҮҮЛЭЭГҮЙ.
- 4.1.10 КЛУБ, БАГУУД ТЭМЦЭЭНИЙ МЭДҮҮЛГИЙГ ҮНЭН ЗӨВ БӨГЛӨЖ ЗӨРЧИЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ТУХАЙН КЛУБ, БАГ БҮРЭН ХАРИУЦНА. КЛУБ, БАГУУД ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ЭРХГҮЙ ТОГЛОГЧИЙГ ТОГЛОЛТОД ОРЧУЛСАН ТОХИОЛДОЛД ТУХАЙН КЛУБ, БАГИЙГ ТЭМЦЭЭНЭЭС ХАСЧ ӨМНӨХ ТОГЛОЛТУУДЫН ОНОО, БӨМБӨГНИЙ ТООГ ХҮЧИНГҮЙД ТООЦНО. МӨНГӨН ТОРГУУЛИЙГ ДАВХАР НООГДУУЛНА.
- 4.1.11 ТОГЛОГЧДЫН БҮРТГЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ХОЛБОГДОЛТОЙ БУСАД АСУУДЛУУДЫГ МХБХ-НЫ ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ ЯВАГДАНА. АЛИВАА ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗӨВХӨН "МХБХ-НЫ ТОГЛОГЧДЫН СТАТУС БА ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЖУРАМ"-ЫН ДАГУУ ҮЙЛДСЭН ТОХИОЛДОЛД ХҮЧИНТЭЙД ТООЦНО.
- 4.1.12 ТЭМЦЭЭНД БҮРТГҮҮЛЖ ОРОЛЦСОН ТОГЛОГЧ ТУХАЙН КЛУБТ БҮРТГЭЛТЭЙГЭЭР ФУТЗАЛЫН УЛИРЛЫГ ДУУСГАНА.



ТАВ. ТЭМЦЭЭНИЙ ЗӨВЛӨГӨӨН БА ЛИГИЙН СУГАЛАА

- 5.11 Техникийн зөвлөгөөн 2024 оны 11 дугаар сарын 27-ний 12:00 цагаас МХБХ-ны байранд зохион байгуулагдана.
- 5.12 Тус зөвлөгөөнд клуб, багийн менежер заавал оролцох шаардлагатай. Тэмцээнтэй холбогдолтой бүх мэдээллийг тус зөвлөгөөнд ТЗБХ-ээс өгөх тул дараа нь Тэмцээний үеэр зохион байгуулалттай холбоотой асуудал гарвал хүлээн авахгүй.
- 5.13 Тус зөвлөгөөнд клубууд тоглогчдын болон хаалгачийн 2 ээлжийн хувцасыг заавал авчирна. Багууд эзэн баг болон зочин багийн өмсгөлүүдээ эцэслэн шийдвэрлэсэн байна. Багчуудын хувцас хэрэглэлтэй холбогдолтой бүх асуудлуудыг МХБХ-ны "Тоглогчдын хувцас хэрэглэлийн журам"-ын дагуу ТЗБХ шийдвэрлэнэ. Тэмцээнд оролцох багчуудын тоглолт бүрийн хувцасны өнгийг ТЗБХ-ээс тодорхойлж эцэслэн зарлана.
- 5.14 Футзалын Тэмцээнд оролцох тоглогчид дүрмийн дагуу шаардлага хангасан өнгө, будаг гардаггүй заалны зориулалтын пүүзтэй байна. Мөн 5 дах тоглогчийн өмсгөлийг зохих шаардлагын дагуу бэлдсэн байна. Өөр төрлийн пүүзтэй тохиолдолд тоглолтод оролцуулахгүй.

ЗУРГАА. ДҮН ГАРГАЛТ

- 6.11 Дараах байдлаар хэсгийн тоглолтын дүнг гаргана.
- Хэрвээ 2 ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна:
- Хоорондын тоглолтын дүнгээр,
 - Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
 - Хоорондын тоглолтын орчулсан бөмбөгний ихээр,
 - Хүснэгтийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
 - Хүснэгтийн бүх тоглолтын орчулсан бөмбөгний ихээр,
 - Багууд талбайд байвал торгучлийн цохилтоор,
 - Fair Play оноо тодруулах зарчимаар
 - Шодолтоор

ДОЛОО. ТЭМЦЭЭНИЙ ҮЕД

- 7.11 Тэмцээнд оролцож буй нийт баг тоглогчид, хөлбөмбөгийн спортыг звсэг, нөхөрсөг, шударга, сонирхолтой байлгахын төлөө "FAIR PLAY" зарчмуудыг тэмцээний турш мөрдөх үүрэгтэй.
- 7.12 Тэмцээний үеэр дасгалжуулагчид, тоглогчдын зүгээс "FAIR PLAY" зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хатуу хяналт тавина.
- 7.13 Тоглолт эхлэхийн өмнө өрсөлдөгч хоёр баг зүгээс "FAIR PLAY" зарчмыг баримтлан тоглохоо илэрхийлж гар барих ёслолыг заавал үйлддэгтэй нэгэн адил тоглолт дуусмагц тоглолтын үр дүнгээс үл хамааран хоёр багийн тоглогчид шүүгч нартай болон өөр хоорондоо гар барих үүрэгтэй. Тухайн тоглолтын эхлэл, төгсгөлд хөгжөөн дэмжигчдэд хүндэтгэл үзүүлнэ. Тоглолтын дараа гар барих ёслол үйлдээгүй тохиолдолд МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагуу арга хэмжээ авна.
- 7.14 Оролцогч талууд тоглолтын талбай ба түүний орчин тойронд биеэ зөв боловсон авч явна.
- 7.15 Тэмцээн зохион байгуулалтын талаарх санал гомдлыг тоглолт дуусаад 2 цагийн дотор ТЗБХ-т бичгээр өгнө.
- 7.16 Шүүгчийн шийдвэртэй холбогдолтой аливаа асуудлыг авч хэлэлцэхгүй.
- 7.17 МХБХ-ны бүх тэмцээний үед гарсан сахилга бат, ёс зүйн холбогдолтой асуудлуудыг МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ээр шийдвэрлэнэ.
- 7.2 Энэ зааварт тусгагдаагүй бусад асуудлыг ТЗБХ тухай бүрт нь шийдвэрлэнэ.



НАЙМ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ, ЭРХИЙН ХУРААМЖ

- 8.1.1 Тэмцээний эхний 4 байр эзэлсэн багт Эрхийн бичиг, Мөнгөн шагнал, Өргөмжлөл, медаль, түрүүлсэн багт "Аваргын Цом" олгоно.
- 8.1.2 1-р байр: 1.500.000 төгрөг.
2-р байр: 1.000.000 төгрөг.
3-р байр: 800.000 төгрөг.
4-р байр: 700.000 төгрөг.
- 8.1.3 Тэмцээний шилдэг баг Нэгдүгээр Лигийн эрх авна.
- 8.1.4 лигийн шилдэг тоглогчдыг шалгаруулж, урамшуулна. Үүнд:
шилдэг хаалгач: цом, батламж 100,000Т мөнгөн шагнал.
шилдэг тоглогч: цом, батламж 100,000Т мөнгөн шагнал.
шилдэг довтлогч: цом, батламж 100,000Т мөнгөн шагнал.
- 8.3.1 МОНГОЛ УЛСЫН ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУЧУЛИЙН ДАГУУ НИЙТ ШАГНАЛЫН САНГИЙН 5% -ИЙГ СЧУТГАН ТООЦОЖ, ТАТВАРЫН БАЙГУУЛАГАД ШИЛЖҮҮЛНЭ.

ЕС. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

- 9.1.1 Тэмцээний үеэр ажиллах хэвлэл мэдээллийн хүмүүсийг албан ёсны зөвшөөрөлтэйгээр тусгайлан зааж өгсөн газар ажиллахыг зөвшөөрнө. Багийн албан ёсны зурагчин тоглолтын үеэр зураг авах тохиолдолд, заавал МХБХ-ны Хэвлэл мэдээллийн ажилтантай холбогдож зохих зөвшөөрөл авч тусгай майктай орно.
- 9.2 МХБХ-ны Хэвлэл мэдээллийн ажилтны шаардлагын дагуу тухайн багийн албан хүн болон тоглогчид яриа өгөх үүрэгтэй.

АРВАН. ТЭМЦЭЭНИЙ САХИЛГА БАТ, ЁС ЗҮЙ

- 10.1 МХБХ-ны бүх тэмцээний үед гарсан сахилга ба ёс зүйн холбогдолтой асуудлуудыг МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ээр шийдвэрлэнэ.
- 10.2 Тэмцээнд оролцох багчид МХБХ-ны "Сахилгын хорооны дүрэм", "Ёс зүйн хорооны дүрэм" - үүдтэй танилцаж, маш сайн ойлголттой байх үүрэгтэй.
- 10.3 Тэмцээний үеэр МХБХ-ны аливаа дүрэм, журамтай танилцаагүй гэсэн тайлбарыг хүлээн авахгүй.

АРВАН НЭГ. ТЭМЦЭЭНИЙ САХИЛГА БАТ, ЁС

- 11.1 МХБХ-ны ТЗБХ-ийн эрх мэдлээс давсан асуудлыг МХБХ-ны тухайн хороодод шилжүүлнэ.
- 11.2 Тэмцээний журам нь дараах хавсралтуудаас бүрдэнэ. Үүнд:
- А. ТЗБЖ Хавсралт 1 Мэдүүлэг
В. ТЗБЖ Хавсралт 3 Хувцасны өнгө
- Нич: Бүх хавсралтуудыг Тэмцээн зохион байгуулах хэлтсээс файлаар дараах цахим хуудсаар хандаж авч болно.



ХАВСРАЛТ 1

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО		ЛОГО	
"....." КЛУБЫН МЭДҮҮЛЭГ.		ХУУДАС	1
ТЭМЦЭЭН	/ ТЭМЦЭЭНИЙ НЭР /		
БАГИЙН АЛБАНЫ ХҮМҮҮСИЙН МЭДҮҮЛЭГ			
	ОВОГ		Баттулга
	НЭР		Эрдэнэбат
	АЛБАН ТУШААЛ		Ахлах Дасгалжүүлэгч
	ИРГЭНШИЛ		Монгол
	УТАСНЫ ДУГААР		99984421
	ЕМАЙЛ ХАЯГ		meduulegmff@gmail.com
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		AFC A
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		

Page 1



ХАВСРАЛТ 2


МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Ш/х-259, Улаанбаатар-210646. Монголын Хөлбөмбөгийн Холбооны төв.
Хан-уул дүүрэг. 15-р хороо. Улаанбаатар. Монгол Улс.
Утас: 345964-17, Факс: 345966



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

“.....” БАГИЙН ХУВЦАСНЫ МЭДҮҮЛЭГ.





ФУТЗАЛЫН СОНИРХОГЧДЫН ЦОМ - 2024